



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2020 оны 12 сарын 01 өдөр

Дугаар А/545

Чингис хот

Бүх нийтийн бэлэн байдлын зэргийг  
бууруулсантай холбогдуулан авах  
зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.3 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын 2020 оны "Бэлэн байдлын зэргийг бууруулах тухай" 194 дүгээр тогтоол, Улсын Онцгой комиссын 2020 оны 37 дугаар хуралдааны шийдвэр, аймгийн Онцгой комиссын 2020 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 38 дугаар хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хэнтий аймгийн хэмжээнд архи, согтууруулах ундааг худалдан борлуулах, түүгээр үйлчлэх үйлчилгээ, олон нийтийг хамарсан хурал зөвлөгөөн, жагсаал цуглаан, соёл урлаг, спортын арга хэмжээ, үзвэр үйлчилгээ зохион байгуулах, сургалтын төв, фитнес бялдаржуулах төв, баар, караоке, цэнгээний газар, компьютер болон биллиард тоглоомын газар, сүм хийд, шашны байгууллагын үйл ажиллагааг 2020 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 06:00 цагаас 2020 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн 06:00 цаг хүртэл хориглосугай.

2. Эвт худалдааны төв болон аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй бараа, барилгын материалын дэлгүүр, ахуй үйлчилгээний газар /гэрэл зургийн үйлчилгээ, цаг засвар, гар утас засвар, оёдолчин, үсчин гоо сайхан, гутал засвар, халуун усны газар/, авто сэлбэгийн худалдаа, авто машин угаалга зэрэг газруудыг 10:00-17:00 цаг, хүнсний дэлгүүр, өөртөө үйлчлэх хоолны газар /буфет/, зоогийн газруудын цагийн хуваарийг 09:00-20:00 цаг, зочид буудал, дэн буудал, дугуй засварын үйл ажиллагааг цагийн хэвийн горимоор ажиллуулахаар тогтоосугай.

3. Дээрх тогтоосон хориглолт, хязгаарлалтын дэглэм, горимын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Цагдаагийн газрын дарга /цагдаагийн хурандаа Б.Батсайхан/, Эрүүл мэндийн газрын дарга /Л.Мэндбаяр/, Мэргэжлийн хяналтын газрын дарга /Б.Сүнгээ/, сумын Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

2.

4. Төрийн байгууллага болон аж ахуй нэгжид хөдөлмөр эрхэлж байгаа 0-12 насны хүүхэдтэй эх /ганц бие эцэг/-ийг байгууллагын хэвийн үйл ажиллагааг алдагдуулахгүйгээр гэрээсээ цахимаар ажиллах боломжийг бүрдүүлж, цалин хөлсийг ажилласанд тооцож олгохыг байгууллага, аж ахуй нэгжийн дарга, удирдлагуудад үүрэг болгосугай.

5. Халдварын сэжигтэй болон батлагдсан тохиолдол шинээр бүртгэгдсэн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжид Гамшгаас хамгаалах тухай хуулийн 11.3.1, 11.3.2-т заасны дагуу холбогдох бэлэн байдлын зэрэгт шилжүүлж, зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг сумдын онцгой комиссын дарга нарт даалгасугай.

6. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч /Ц.Чогсомжав/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ИДЭРБАТ